

**МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ
АССОЦИАЦИЙН ДЭРГЭДЭХ
БАРИЛГА,
ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН
АРБИТРЫН АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЖУРАМ

1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ.....	2
2 дугаар зүйл. Дүрмийн нэр томъёоны тодорхойлолт.....	2
3 дугаар зүйл. Баримт бичиг хүргэх, хугацаа тооцох.....	3
4 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа эхлэх.....	4
5 дугаар зүйл. Нэхэмжлэл ба сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн.....	5
6 дугаар зүйл. Хариу тайлбар.....	5

ХОЁР. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН

7 дугаар зүйл. Арбитрчийн тоо, томилгоо.....	6
8 дугаар зүйл. Нэг арбитрчийг томилох.....	6
9 дүгээр зүйл. Гурван арбитрчийг томилох.....	7
10 дугаар зүйл. Арбитрчид тавигдах шаардлага.....	7
11 дүгээр зүйл. Арбитрчийг татгалзан гаргах.....	8
12 дугаар зүйл. Арбитрчийг нөхөн томилох.....	8

ГУРАВ. АРБИТРЫН АЖИЛЛАГАА

13 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны журам тогтоох.....	9
14 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал.....	10
15 дугаар зүйл. Маргааны харьяалал.....	10
16 дугаар зүйл. Арбитрын ажиллагааг нэгтгэх, оролцогч нэмэгдэх.....	11
17 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны хэл.....	11
18 дугаар зүйл. Талуудын тэгш байдал.....	12
19 дүгээр зүйл. Нотлох баримт.....	12
20 дугаар зүйл. Арбитрын хуралдаан.....	13
21 дүгээр зүйл. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ.....	14
22 дугаар зүйл. Татгалзах эрхээ алдах.....	14

ДӨРӨВ. АРБИТРЫН ШИЙДВЭР

23 дугаар зүйл. Арбитрын шийдвэр, тогтоол гаргах.....	15
24 дүгээр зүйл. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах.....	15
25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ.....	16
26 дугаар зүйл. Арбитрын зардал.....	16
27 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа дуусгавар болох.....	16

ТАВ. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

28 дугаар зүйл. Түргэвчилсэн ажиллагаа.....	17
29 дүгээр зүйл. Нууцлал.....	18
30 дугаар зүйл. Хариуцлага.....	19

АРБИТРЫН АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЖУРАМ

1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ

1.1. Талууд маргаанаа Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн дэргэдэх Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитр (цаашид “**Арбитр**” гэнэ)-аар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон эсхүл Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын ажиллагааны дүрэм (цаашид “**Дүрэм**” гэнэ)-ийн дагуу шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон (маргаан үүсэхээс өмнө эсхүл дараа тохиролцсоноос үл хамааран) бол талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх Дотоодын арбитрын ажиллагаанд энэхүү Дүрмийг баримтална.

1.2. Жишиг загвар: (а) Олон улсын арбитрын ажиллагаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдааны Эрх Зүйн Комиссоос баталсан Арбитрын загвар Дүрэм (UNCITRAL Arbitration Rules)-ийг хэрэглэнэ. (б) Энэхүү дүрмийг боловсруулахдаа МҮХАЙТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмийг жишиг болгосон. Дүрмийн заалтыг тайлбарлахад эргэлзээ үүсвэл жишиг загваруудын талаар шүүх болон арбитрын шийдвэрийг арга зүйн хувьд ашиглаж болно.

1.3. Энэхүү Дүрмийг хэрэглэхтэй холбоотой удирдамжийг Арбитрчдын зөвлөл баталж болно.

1.4. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын ажиллагаанд энэхүү Дүрмийг баримтална.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ Дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Арбитрын бүрэлдэхүүн” гэж тухайн маргааныг шийдвэрлэх нэг буюу хэд хэдэн арбитрчийг;

2.1.2. “Нэхэмжлэгч” гэж арбитрын ажиллагааг эхлүүлэхээр нэхэмжлэл гаргасан нэг буюу хэд хэдэн этгээд, тэдгээртэй арбитрын ажиллагааг нэгтгэх эсхүл өөр хэлбэрээр нэгдэн нийлсэн этгээдийг;

2.1.3. “Хариуцагч” гэж Нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсан Хариуцагч, хамтран Хариуцагч, тэдгээртэй арбитрын ажиллагааг нэгтгэх эсхүл өөр хэлбэрээр нэгдэн нийлсэн этгээдийг;

2.1.4. “Арбитрын ажиллагааны оролцогч” гэж Талууд, тэдгээрийн Төлөөлөгч болон арбитрын ажиллагаанд оролцож буй гэрч, хэлмэрч, орчуулагч, шинжээчийг;

2.1.5. “Талууд” гэж Нэхэмжлэгч, Хариуцагчийг;

2.1.6. “Бусад оролцогч” гэж Нэхэмжлэгч, Хариуцагчаас Бусад оролцогчийг;

2.1.7. “Төлөөлөгч” гэж Талуудын итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, баримт бичгийн үндсэн дээр төлөөлөх эрх бүхий этгээд болон тэдгээрийн томилсон хуулийн зөвлөх, өмгөөлөгч, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчийг бүгдийг эсхүл аль нэгийг;

2.1.8. “Арбитрын ажиллагаанд мэдэгдсэн хаяг” гэж арбитрын ажиллагааны явцад Баримт бичиг, мэдэгдэл хүлээн авахаар Талуудаас мэдэгдсэн хаяг;

2.1.9. “Арбитрын эрх бүхий этгээд” гэж Арбитрчдын зөвлөлөөс томилсон этгээдийг;

2.1.10. “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэж хүндээр өвчилсөн буюу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон зэрэг өөрөөс үл хамаарах шалтгаанаар арбитрын ажиллагаанд биечлэн болон цахимаар оролцох боломжгүй нөхцөл байдлыг;

2.1.11. “Арбитрын ажиллагааны харьяалал” гэж арбитрын ажиллагаа аль улсын хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах харьяаллыг;

- 2.1.12. “Дүгнэлт-тайлбар” /post hearing brief/ гэж хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдож буй үйл баримтын талаарх эцсийн дүгнэлт, хууль зүйн үндэслэл бүхий санал, тайлбар;
- 2.1.13. “Баримт бичиг” гэж цаасан дээр, эсхүл цахим, дуу, дүрсний болон бусад хэрэгслээр бичсэн буюу хадгалсан бүх төрлийн бичвэр, харилцаа холбоо, фото зураг, гар зураг, программ, өгөгдлийг;
- 2.1.14. “Харилцаа холбооны бусад хэрэгсэл” гэж Мэдээллийн өгөгдөл ашигласан аливаа харилцааг;
- 2.1.15. “Мэдээллийн өгөгдөл” гэж цахим, соронзон, гэрлийн болон бусад ижил төстэй арга хэлбэрээр бий болгосон, илгээсэн, хүлээн авсан, эсхүл хадгалсан мэдээлэл цахим өгөгдөл солилцоо, цахим шуудан, телекс, телефакс, нийгмийн сүлжээг;
- 2.1.16. “Хүргэсэн” гэж Баримт бичиг, мэдэгдлийг хүлээн авагчийн хаягаар шуудан болон Харилцаа холбооны бусад хэрэгслээр илгээж, хүлээн авагч хүлээн авах боломжтой нөхцөл бүрдсэнийг;
- 2.1.17. “Бүртгэгч” гэж Арбитрын ажлын албаны нэхэмжлэл хүлээн авч бүртгэл хөтлөх чиг үүргийг хариуцсан ажилтныг хэлнэ;
- 2.1.18. “Олон улсын арбитрын ажиллагаа” гэж Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасныг ойлгоно;
- 2.1.19. “Дотоодын арбитрын ажиллагаа” гэж Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасныг ойлгоно.

Здугаар зүйл. Баримт бичиг хүргэх, хугацаа тооцох

- 3.1. Энэхүү Дүрмийн дагуу илгээх Баримт бичиг, мэдэгдлийг доорх байдлаар хүргэсэн тохиолдолд тэдгээрийг хүлээн авсанд тооцно. Үүнд:
- 3.1.1. хүлээн авагч талд биечлэн хүргэснээр, эсхүл Арбитрын ажиллагаанд мэдэгдсэн хаяг баталгаат шуудангаар хүргэснээр;
- 3.1.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад зааснаар хүргэх боломжгүй бол бүртгэлтэй эсхүл үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа газрын хаягт баталгаат шуудангаар илгээснээр;
- 3.1.3. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад зааснаар хүргэх боломжгүй бол холбогдох гэрээнд дурдсан хаягт баталгаат шуудангаар, факс дугаар эсхүл цахим шууданд илгээснээр;
- 3.1.4. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3 дахь заалтуудад зааснаар хүргэх боломжгүй бол хамгийн сүүлд мэдэгдэж байсан хаягт баталгаат шуудангаар илгээснээр, эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан цахим шуудан, Харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглаж илгээснээр.
- 3.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу Баримт бичиг, мэдэгдлийг Хүргэсэн, эсхүл илгээсэн өдөр нь түүнийг хүлээн авсан өдөрт тооцогдоно.
- 3.3. Дүрмийн дагуу явагдах арбитрын ажиллагааны хугацааг Талууд өөрөөр тохиролцоогүй бол Монгол Улсын Нийслэл Улаанбаатарын цагаар буюу UTC+8 цагийн бүсээр тооцно.
- 3.4. Хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцож байгаа тохиолдолд мэдэгдэл, баримт бичгийг энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хамгийн сүүлийн хүлээн авагчид хүргэснээр тухайн Нэхэмжлэгч, Хариуцагч тус тус хүлээн авсанд тооцно.
- 3.5. Нэхэмжлэгч, Хариуцагч нь аливаа баримт бичгийн нэг хувийг Арбитрын хэргийн хавтаст зориулан, хуулбарыг Арбитрын бүрэлдэхүүн, Нэхэмжлэгч, Хариуцагчийн тоогоор хувилж Арбитрт ирүүлнэ. Арбитрын бүрэлдэхүүн хувилж ирүүлэх тоог өөрөөр тогтоож болно.

3.6. Хугацааг хуанлийн өдрөөр тоолох бөгөөд энэхүү Дүрэмд заасан хугацаа нь баримт бичгийг хүлээн авсан эсхүл хүлээн авсан гэж тооцсон өдрийн дараагийн өдрөөс эхлэн тоолно.

3.7. Хэрэв тогтоосон хугацааны сүүлийн өдөр нь амралтын, нийтээр амрах баярын өдөр эсхүл хүлээн авагчийн оршин байгаа улс орны нийтийг хамарсан баяр, амралтын өдөр бол энэ хугацаа дараагийн ажлын өдөр дуусна.

4 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа эхлэх

4.1. Энэхүү Дүрмийн дагуу Нэхэмжлэгч маргаанаа арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэлээ Арбитрын ажлын албанд хүргэнэ.

4.2. Нэхэмжлэл нь дараах зүйлээс бүрдэнэ:

4.2.1. Нэхэмжлэгчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар, регистрийн дугаар;

4.2.2. Хариуцагчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг эсхүл оршин байгаа газар;

4.2.3. Талуудын холбоо барих утас, цахим шуудан, шуудангийн хаяг;

4.2.4. нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;

4.2.5. арбитрын хэлэлцээр ба маргааны харьяаллын тухай тайлбар;

4.2.6. нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн.

4.3. Нэхэмжлэлд арбитрын үндсэн зардлыг төлсөн баримт, арбитрын хэлэлцээр, маргаан үүсэх үндэслэл болсон гэрээ, холбогдох бусад Баримт бичиг, түүнчлэн нэхэмжлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд гаргасан бол төлөөлөх эрхтэйг нотолсон баримтыг тус тус хавсаргана.

4.4. Арбитрын ажлын албанд ирүүлсэн нэхэмжлэлийг Бүртгэгч хүлээн авч Арбитрын бүрэлдэхүүн томилогдох хүртэл хугацаанд дараах ажиллагааг хийнэ:

4.4.1. Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгүүдэд заасан бүрдүүлбэрийг хангуулах;

4.4.2. Арбитрын бүрэлдэхүүнийг томилохыг Талуудад мэдэгдэх, томилоогүй бол эрх бүхий этгээдээр томилуулах;

4.4.3. арбитрын ажиллагааны хугацаа тоолох, сунгах, тогтоох;

4.4.4. арбитрын ажиллагаа, холбогдох Дүрэм журмын талаарх мэдээллээр Талуудыг хангах; яаралтай арбитрчийг томилуулах арга хэмжээ авах;

4.4.5. арбитрын үндсэн зардлын хэмжээг тодорхойлох, зардлыг төлүүлэх.

4.5. Нэхэмжлэлийг Хариуцагч хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ. Хүлээн авсан өдрийг Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу тогтооно.

4.6. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр дутуу гэдэг үндэслэлээр Арбитрын бүрэлдэхүүн томилогдоход саад болохгүй. Үүнтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэнэ.

4.7. Арбитрын ажиллагааг удаашруулах, аль нэг талд ялгавартай байдлыг үүсгэх үр дагавартай гэж Арбитрын бүрэлдэхүүн үзсэнээс бусад тохиолдолд арбитрын ажиллагааны аль ч шатанд Талууд нэхэмжлэлийн шаардлага болон хариу тайлбарт нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5 дугаар зүйл. Нэхэмжлэл ба сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн

5.1. Бүртгэгч эсхүл Арбитрын бүрэлдэхүүн арбитрын үндсэн зардлын хэмжээг тогтоох зорилгоор нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнг дараах байдлаар тодорхойлж болно:

5.1.1. Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бол түүний дүнгээр;

5.1.2. Гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах бол уг гэрээ хэлцлийн үнийн дүнгээр;

5.1.3. Эд хөрөнгө гаргуулах бол уг эд хөрөнгийн үнийн дүнгээр, үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр;

5.1.4. Эрхийн харилцааг хүлээн зөвшөөрөх буюу өөрчлөх бол тухайн эрхийн шаардлага гаргах үеийн үнэлгээгээр;

5.1.5. Тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг даалгах тухай шаардлагын хувьд тухайн шаардлагад хамаарах хөрөнгийн сонирхолд үндэслэсэн дүнгээр;

5.1.6. Хэд хэдэн шаардлага тавьсан нэхэмжлэлд, шаардлага бүрийн үнийн дүнг тус бүрд нь тодорхойлох бөгөөд нэхэмжлэлийн үнийг бүх шаардлагын нийлбэр дүнгээр тодорхойлно.

5.2. Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнг тодорхойлоогүй эсхүл буруу тодорхойлсон байвал уг үнийн дүнг Арбитрын бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар эсхүл аль нэг талын хүсэлтээр тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

6 дугаар зүйл. Хариу тайлбар

6.1. Хариуцагч нь нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоног, түргэвчилсэн журмаар маргаан шийдвэрлэх бол 7 хоногийн дотор хариу тайлбарыг Арбитрт ирүүлнэ. Хариу тайлбарт дараах мэдээллийг тусгана:

6.1.1. Хариуцагч, түүний Төлөөлөгчийн овог, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг эсхүл оршин байгаа газар, холбоо барих утас, цахим шуудан, шуудангийн хаяг;

6.1.2. арбитрын харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох тайлбар;

6.1.3. нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч буй, эсхүл хүлээн зөвшөөрөхгүй татгалзаж буй тайлбар;

6.1.4. хариу тайлбарыг дэмжиж буй үйл баримт, хууль зүйн үндэслэл;

6.2. Хариу тайлбарыг төлөөлөх эрх бүхий этгээд гаргах ба төлөөлөх эрхтэйг нотолсон баримтыг хавсаргана.

6.3. Хариуцагч нь хариу тайлбараа Арбитрт ирүүлэх бөгөөд Арбитр нь хариу тайлбарын хувийг Нэхэмжлэгчид хүргэнэ.

6.4. Хариуцагч нь хариу тайлбарыг тогтоосон хугацаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй нь арбитрын ажиллагааг үргэлжлүүлэхэд саад болохгүй.

6.5. Хариуцагч үндсэн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

6.6. Нэмэгдүүлсэн шаардлага, сөрөг нэхэмжлэлийн шаардлагад Талууд Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд хариу тайлбар ирүүлнэ.

6.7. Хариуцагч хариу тайлбар гаргаагүй, дутуу эсвэл хугацаа хожимдуулсан нь Арбитрын бүрэлдэхүүнийг томилоход саад учруулах үндэслэл болохгүй ба үүнтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн эцсийн шийдвэрийг гаргана.

ХОЁР. АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН

7 дугаар зүйл. Арбитрчийн тоо, томилгоо

7.1. Дүрмийн дагуу маргааныг хянан шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоо нэг, эсхүл гурав байна. Талууд маргааныг хянан шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоог харилцан тохиролцоогүй бөгөөд маргааныг түргэвчилсэн журмаар шийдвэрлэхээс бусад тохиолдолд тухайн маргааныг шийдвэрлэх Арбитрын бүрэлдэхүүний тоо гурав байна.

7.2. Маргааныг түргэвчилсэн журмаар шийдвэрлэж байгаа тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүний тоог Дүрмийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад заасны дагуу тогтоож томилно.

7.3. Талууд арбитрчийг Арбитрын арбитрчдын жагсаалтаас сонгож томилно. Арбитр нь арбитрчийн ажлын туршлага, мэргэжлийн ур чадварын талаар нээлттэй мэдээлнэ.

7.4. Арбитрын эрх бүхий этгээд нь арбитрчийг томилохдоо Талуудын шаардлагыг хангаж байгаа эсэх, арбитрчийн туршлага, мэргэшсэн байдал, ажиллах боломж болон бусад байдлыг харгалзан үзнэ.

7.5. Энэхүү Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.4 дэх хэсэгт тус тус заасан асуудлаар гаргасан Арбитрын эрх бүхий этгээдийн шийдвэр эцсийн байна.

7.6. Энэхүү Дүрэмд заасан хугацаанд эсхүл нэхэмжлэл гаргах, хариу тайлбар өгөхдөө арбитрч томилох саналыг арбитрт ирүүлж болно.

8 дугаар зүйл. Нэг арбитрчийг томилох

8.1. Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон, эсхүл аль нэг тал нь санал гаргасан, тухайн саналыг нөгөө тал нь хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор татгалзаагүй тохиолдолд нэг арбитрчаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

8.2. Талууд арбитрчийн тоог нэг байхаар тохиролцсон тохиолдолд Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилно.

8.3. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцох тохиолдолд арбитрын ажиллагаа эхэлснээс хойш 14 хоногийн дотор Талууд хамтран нэг арбитрчийг харилцан тохиролцож томилно.

8.4. Хэрэв Талууд Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2-8.3 дахь хэсэгт заасан хугацаанд хэргийг шийдвэрлэх нэг арбитрчийг харилцан тохиролцож томилж чадаагүй бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрчийг томилно.

9 дүгээр зүйл. Гурван арбитрчийг томилох

9.1. Талууд арбитрын ажиллагаа эхэлснээс хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилно. Энэ хугацаанд Талууд арбитрчаа томилоогүй бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрчийг томилно.

9.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол томилогдсон хоёр арбитрч нь гурав дахь арбитрчийг томилох бөгөөд ийнхүү томилогдсон гурав дахь арбитрч нь даргалагч арбитрч

байна. Талуудын томилсон арбитрчид ийнхүү томилогдсоноос хойш 14 хоногийн дотор даргалагч арбитрчийг томилоогүй бол Арбитрын эрх бүхий этгээд томилно.

9.3. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Нэхэмжлэгч, Хариуцагч оролцох тохиолдолд Талууд арбитрчийн тоог тохиролцоогүй бол Нэхэмжлэгчид хамтран нэг арбитрчийг, Хариуцагчид хамтран нэг арбитрчийг 14 хоногийн дотор тус тус томилно.

9.4. Дүрэмд заасан хугацаанаас өмнө Талууд арбитрчаа, мөн Талуудын томилсон арбитрчид даргалагч арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээдээр томилуулах хүсэлтийг гаргаж болно.

10 дугаар зүйл. Арбитрчид тавигдах шаардлага

10.1. Арбитрч нь арбитрын ажиллагааны туршид хараат бус, бие даасан байна. Арбитрч тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ аливаа хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дайчилж ажиллана.

10.2. Арбитрчаар томилогдсон этгээд тухайн маргаанд ажиллахаа хүлээн зөвшөөрөхөөс өмнө Талуудын талаарх мэдээлэл, нэхэмжлэлтэй танилцан өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэх дараах нөхцөл байдлын талаар арбитрын ажлын албанд мэдэгдэх үүрэгтэй:

10.2.1. Талуудын харилцан тохиролцсон шаардлагыг хангаж байгаа эсэх;

10.2.2. Талуудтай аливаа маргаантай асуудлаар сүүлийн 2 жилийн хугацаанд шүүх, арбитраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч, гуравдагч этгээд, гэрч, шинжээч, орчуулагчаар оролцож байсан эсэх;

10.2.3. төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн холбоо, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;

10.2.4. Талуудад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан, аж ахуйн болон бусад хэлбэрээр нэгдмэл сонирхолтой эсэх;

10.2.5. бусад нөхцөл байдлын улмаас хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээтэй эсэх.

10.3. Арбитрч арбитрын ажиллагааны явцад өмнө нь мэдэгдэж байснаас бусад хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлж болох нөхцөл байдал илэрсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлын талаар арбитрын ажиллагааны аль ч үед Арбитр болон Талуудад нэн даруй бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлдээ арбитрчаар ажиллах, эсхүл татгалзах тухай саналаа тусгана.

10.4. Арбитрчийн ажиллах боломж, бие даасан, хараат бус байдлын талаарх мэдээллийг Талууд арбитрчийг томилохоос өмнө, хэрэв арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээд томилсон бол томилсон тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Арбитраар дамжуулан авч болно.

10.5. Талууд болон түүний Төлөөлөгчид нь арбитрчтай тухайн арбитрын ажиллагаатай холбоотой асуудлаар ганцаарчилсан уулзалт хийх, холбогдох, зүй бус нөлөөлөхийг хориглоно. Энэ талаар тухайн арбитрч Арбитрт мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэн нь арбитрчаас татгалзах үндэслэл болохгүй.

11 дүгээр зүйл. Арбитрчийг татгалзан гаргах

11.1. Аль нэг арбитрчийн хараат бус, бие даасан байдлын талаар үндэслэл бүхий эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал бий болсон гэж үзвэл тухайн арбитрчийг татгалзан гаргаж болно.

11.2. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтэй тал нь Дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын талаар мэдсэн болон мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 14 өдрийн дотор татгалзан гаргах үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр үйлдэн Арбитрын бүрэлдэхүүнд гаргана.

11.3. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг нөгөө тал зөвшөөрөөгүй, эсхүл тухайн арбитрч өөрийн хүсэлтээр татгалзан гараагүй бол тухайн арбитрчийг оролцуулалгүйгээр Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Хэрэв арбитрчийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэхэд Арбитрын бүрэлдэхүүний санал зөрсөн, эсхүл Арбитрын бүрэлдэхүүнээс бүхэлд нь татгалзсан бол татгалзан гаргах хүсэлтийг Арбитрын эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

11.4. Арбитрчаас татгалзан гаргах хүсэлтийг нөгөө тал зөвшөөрсөн бол тухайн арбитрчийг татгалзсан гэж үзнэ.

11.5. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй бол Арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргаж болно.

11.6. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтэд дурдсан үндэслэл байхгүй гэж үзвэл арбитрч өөрийн хүсэлтээр татгалзан гарах эрхгүй.

11.7. Аль нэг талын хүсэлтийн дагуу арбитрчийг татгалзан гаргасан нь даргалагч арбитрч болон бусад арбитрчийг өөрчлөх, татгалзан гаргах үндэслэл болохгүй.

12 дугаар зүйл. Арбитрчийг нөхөн томилох

12.1. Татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авсан, өөрийн хүсэлтээр татгалзан гарсан арбитрчийг анх томилоход үйлчилж байсан журмын дагуу шинээр нөхөн томилно.

12.2. Арбитрч нөхөн томилогдсон тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол арбитрч нөхөн томилогдсон үеэс арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

12.3. Арбитрч нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан, эрх, үүргээ хэрэгжүүлэх чадамжгүй болсон гэж үзвэл Арбитрын эрх бүхий этгээд тухайн арбитрчийн арбитрын ажиллагааны эрх үүргийг дуусгавар болгож, энэ тухай Талуудад болон Арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэнэ. Арбитрчийг Дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу нөхөн томилно.

ГУРАВ. АРБИТРЫН АЖИЛЛАГАА

13 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны журам тогтоох

13.1. Арбитрын бүрэлдэхүүн нь арбитрын ажиллагааг Талуудын эрх тэгш байдал болон өөрсдийн байр суурийг илэрхийлэх боломжоор хангасан, шуурхай, үр дүнтэй, Талуудын саналыг харгалзан тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр явуулна.

13.2. Арбитрын бүрэлдэхүүн Талуудтай зөвшилцсөний үндсэн дээр боломжит богино хугацаанд арбитрын ажиллагааны бэлтгэлийг хангах, ажиллагааны явцад Талуудаас тайлбар, хүсэлт, нотлох баримт, сөрөг нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөн гаргах цаг хугацааны хуваарийг тогтоох зорилгоор урьдчилсан хуралдааныг танхимаар болон цахимаар явуулна.

13.3. Урьдчилсан хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

13.3.1. арбитрын харьяалал;

13.3.2. арбитрын ажиллагааны журам

13.3.3. Талуудаас гаргасан хүсэлт;

13.3.4. арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ;

13.3.5. үндсэн хуралдааныг хийх хэлбэр, тов;

13.3.6. бусад.

13.4. Арбитрын харьяаллын талаар маргаантай гэж үзвэл Арбитрын бүрэлдэхүүн тусгайлан хэлэлцэж, шийдвэр гаргана.

13.5. Урьдчилсан хуралдаанаар дараах зүйлсийг тусгасан арбитрын ажиллагааны журмыг батална:

13.5.1. Талууд, тэдгээрийн албан ёсны нэр, хаяг;

13.5.2. арбитрын ажиллагааны товч мэдээлэл;

13.5.3. нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэл болон хариу тайлбарын товч агуулга;

13.5.4. Талуудын маргаж буй зүйл ба Арбитрын бүрэлдэхүүний тогтоох шаардлагатай асуудал;

13.5.5. арбитрын хэлэлцээр;

13.5.6. арбитрын харьяалал;

13.5.7. нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүн, арбитрын зардал;

13.5.8. арбитрын ажиллагаа явуулах газар;

13.5.9. арбитрын ажиллагаа явуулах хэл;

13.5.10. арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүй;

13.5.11. арбитрын хуралдааны тов;

13.5.12. арбитрын хуралдааныг явуулах арга, хэлбэр;

13.5.13. арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ;

13.5.14. арбитрын хуралдааныг цахимаар явуулах тохиолдолд цахим хурлын удирдамж;

13.5.15. арбитрын ажиллагаанд Төлөөлөгч, бусад этгээдийг оролцуулах, хэргийн материал, Баримт бичигтэй танилцах, тохиролцсон болон тогтоосон хугацааг баримтлах Талуудын үүрэг;

13.5.16. Талуудын гаргаж өгөх Баримт бичиг, хүсэлт, сөрөг нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх, нотлох баримт бүрдүүлэх, гэрч шинжээч, үзлэг, хэлмэрч, орчуулагч томилох, шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт, тэдгээрийг Арбитрт ирүүлэх хугацаа болон хуваарь;

13.5.17. арбитрын ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авах этгээд, хүргэх арга хэрэгсэл;

13.5.18. Арбитрын ажиллагааны журмыг баталгаажуулах хэлбэр, арга хэрэгсэл.

13.6. Аль нэг тал нь арбитрын ажиллагааны журамд заасан хугацааг баримтлаагүй, тохиролцсон болон тогтоосон хугацаанд эрхээ эдлээгүй бол эрхээсээ татгалзсан буюу эрхээ эдэлсэн гэж үзнэ.

13.7. Аль нэг тал нь урьдчилсан хуралдаанаар тогтоох Арбитрын ажиллагааны журамд бичгээр санал ирүүлсэн бол Арбитрын бүрэлдэхүүн уг саналыг Арбитрын ажиллагааны журмыг батлахдаа харгалзан үзэж болно.

13.8. Урьдчилсан хуралдаанд аль нэг тал Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд түүний эзгүйд, хуралдаанд оролцогч талын саналыг харгалзан урьдчилсан хуралдааныг явуулж болно.

13.9. Арбитрын ажиллагааны журмыг Арбитрын бүрэлдэхүүн болон Талууд баталгаажуулна. Аль нэг тал баталгаажуулаагүй, баталгаажуулахаас татгалзсан нь журмын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

13.10. Даргалагч арбитрч нь арбитрын үндсэн шийдвэр гаргах, шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах, арбитрын ажиллагааны журмыг тодорхойлох, арбитрчийг татгалзан гаргах, нөхөн томилохоос бусад арбитрын ажиллагаанд холбогдох хуралдааны бэлтгэл хангах болон үндсэн хуралдаанаас бусад хуралдааны хэлбэр, тов тогтоох асуудлыг дангаар шийдэж болно.

14 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал

14.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын ажиллагааны харьяалал Монгол Улс байна.

14.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөх, гэрч, шинжээч, Талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, Баримт бичигт үзлэг хийх, арбитрын хуралдаан явуулах зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно. Энэ нь харьяаллыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

15 дугаар зүйл. Маргааны харьяалал

15.1. Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаан нь Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын харьяаллын маргаан мөн эсэх, Талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэх, арбитрын хэлэлцээрийн хүрээнд хамаарах эсэхийг өөрөө тогтоох эрхтэй.

15.2. Дараах тохиолдолд Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын харьяаллын маргаан гэж үзнэ:

15.2.1. Талууд Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлэх эсхүл хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх хэлэлцээртэй;

15.2.2. Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрыгссонгосон гэж арбитрын хэлэлцээрийг тайлбарлахаар бол;

15.2.3. Арбитрын хэлэлцээрт энэхүү Дүрмийг хэрэглэхээр тохиролцсон;

15.2.4. Арбитрын хэлэлцээрийн нэг тал нь нэхэмжлэл гаргасан бөгөөд Хариуцагч хариу тайлбар гаргах 30 хоногийн дотор харьяаллын талаар маргаагүй;

15.2.5. Монголын Барилгын Үндэсний Ассоциаци болон бусад мэргэжлийн холбоодын дүрэм, гэрээний нөхцөл зэрэг Баримт бичигт арбитрын хэлэлцээр тусгагдсан бол тухайн байгууллагын гишүүд хооронд үүссэн маргаан;

15.2.6. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан.

16 дугаар зүйл. Арбитрын ажиллагааг нэгтгэх, оролцогч нэмэгдэх

16.1. Дүрмийн дагуу явагдаж буй арбитрын хэд хэдэн ажиллагааг нэгтгэх хүсэлт гаргасан тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн доорх тохиолдлуудад нэгтгэж болно:

16.1.1. Талууд арбитрын ажиллагааг нэгтгэхийг хүлээн зөвшөөрсөн;

16.1.2. тухайн нэхэмжлэлүүд нь нэг арбитрын хэлэлцээрт үндэслэсэн;

16.1.3. нэхэмжлэлүүд нь хууль болон үйл баримтын хувьд нийтлэг асуудлыг хөндсөн, нэг хэлцэл эсхүл хамаарал бүхий хэд хэдэн хэлцлүүдээс үүссэн.

16.2. Хэд хэдэн ажиллагааг нэгтгэх тохиолдолд эхэнд эхэлсэн арбитрын ажиллагаанд нэгтгэнэ.

16.3. Дүрмийн дагуу явагдаж буй арбитрын ажиллагаанд гуравдагч этгээд шинээр маргааны тал болж нэмэгдэж оролцох хүсэлт гаргасан бол Арбитрын бүрэлдэхүүн Талуудын саналыг харгалзан, арбитрын хэлэлцээр, маргааны агуулга болон бусад холбогдох нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр арбитрын ажиллагаанд оролцуулах эсэхийг шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны хэл

17.1. Арбитрын ажиллагааг Талууд өөрөөр тохиролцоогүй бол монгол хэлээр явуулна.

17.2. Шаардлагатай тохиолдолд Талуудын хүсэлтийг үндэслэн арбитрын ажиллагаанд хэд хэдэн хэл хэрэглэх нөхцөл, журмыг Арбитрын бүрэлдэхүүн тодорхойлж болно.

17.3. Талууд эсхүл арбитраас тогтоосон хэлийг арбитрын бүхий л ажиллагаанд Талуудын өргөдөл, тайлбар бичих, хуралдаан явуулах, арбитрын шийдвэр, бусад мэдэгдэл гаргахад хэрэглэнэ.

17.4. Арбитрын бүрэлдэхүүн шинжээчийн дүгнэлт болон бусад бичгээр гаргасан нотлох баримтыг Талууд болон Арбитрын бүрэлдэхүүний тогтоосон хэл рүү бүхэлд нь эсхүл хэсэгчлэн орчуулахыг Талуудаас шаардана.

17.5. Талууд арбитрын ажиллагаанд хэлмэрч, орчуулагчтай оролцож болох бөгөөд энэхүү хэлмэрч, орчуулгын үнэн зөв болон хэлмэрч, орчуулгын зардлыг Талууд өөрсдөө хариуцна.

17.6. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн хэлмэрч, орчуулагч томилж болно.

17.7. Арбитрын бүрэлдэхүүнд хэд хэдэн улсын арбитрчид орсон нөхцөлд тухайн орчуулагчаас нууц хадгалах баталгаа гаргуулан авч зөвлөлдөх тасалгаанд орчуулагчийн тусламжийг авч болно.

18 дугаар зүйл Талуудын тэгш байдал

18.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд өөрсдийн байр суурийг илэрхийлэх, мэтгэлцэх боломжоор бүрэн хангагдана.

18.2. Талууд арбитрын ажиллагааны явцад болон хуралдааны үед тайлбар, хүсэлт, гомдол гаргах эрхээ эдлэх боломжтой боловч энэ эрхээ эдлээгүй дараагийн ажиллагаанд оролцсон бол эрхээ эдэлсэн гэж үзнэ.

18.3. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тэгш оролцоо, тэнцвэртэй байдлыг хангаж, арбитрын ажиллагааг цаг хугацаа, зардлын зохистой арга хэлбэрээр явуулна.

18.4. Талууд арбитрын ажиллагаанд Төлөөлөгчөөрөө дамжуулан эрх, үүргээ хэрэгжүүлж болно. Аль нэг талын Төлөөлөгч, түүний бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь арбитрын ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

18.5. Талууд болон тэдгээрийн Төлөөлөгч арбитрын ажиллагаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, мөн арбитрын хуралдаанд ирээгүй, хуралдааныг орхин гарсан нөхцөлд, нөгөө талын саналыг харгалзан арбитрын ажиллагаа буюу хуралдааныг ердийн журмаар үргэлжлүүлнэ.

18.6. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн Төлөөлөгч оролцуулж байгаа талын аль нэг нь Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас арбитрын хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох боломжгүй нөхцөлд тухайн этгээдийг солих боломжтой эсхүл тухайн этгээдийг оролцуулахгүйгээр хуралдааныг явуулах боломжтой бол арбитрын хуралдааныг үргэлжлүүлж болно.

18.7. Талууд өөрийн Төлөөлөгчөө боломжит хугацааны өмнө томилж, арбитрын ажиллагаанд бэлтгэх, хэргийн материал, Баримт бичиг, мэдэгдэлтэй танилцуулах, хуралдаанд оролцох боломж, нөхцөлөөр хангах үүрэг хүлээнэ. Энэхүү үүргээ биелүүлээгүй нь арбитрын ажиллагаанд саад болохгүй.

19 дүгээр зүйл. Нотлох баримт

19.1. Талууд өөрийн нэхэмжлэл, хариу тайлбар, татгалзалд дурдсан үйл баримтыг нотлох үүрэгтэй.

19.2. Талууд нотлох баримтыг нэхэмжлэл, хариу тайлбарын хамт эсхүл Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүний тогтоосон хугацаанд ирүүлнэ. Уг хугацаанд ирүүлээгүй тохиолдолд нотлох баримтыг хүлээж авах эсэхийг Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

19.3. Нотлох баримт нь Талуудын тайлбар, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, үзлэгийн тэмдэглэл, бичмэл, цахим болон бусад хэлбэртэй байж болно.

19.4. Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр тогтоогоогүй бол Талууд гэрчийн мэдүүлгийг бичгээр гаргуулж, гарын үсэг зуруулан арбитрт ирүүлж болно. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн Талуудын хүсэлтийг үндэслэж гэрчийг хуралдаанд оролцуулах хэлбэр, журмыг тогтооно.

19.5. Талууд шинжээчийн дүгнэлтийг бичгээр гаргуулж арбитрт ирүүлж болно.

19.6. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцоог үндэслэн шаардлагатай гэж үзвэл шинжээчийг томилж болно.

19.7. Шинжээч нь нэг эсхүл хэд хэдэн шинжээчээс бүрдэж болно.

19.8. Талуудын хүсэлтийг үндэслэн үзлэг хийх арга, журмыг Арбитрын бүрэлдэхүүн тогтооно.

19.9. Арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна. Тухайн нотлох баримтыг хуурамч, хууль бус аргаар цуглуулсан гэж Арбитрын бүрэлдэхүүн үзвэл уг баримтыг нотлох чадваргүйд тооцож хүлээн авахаас татгалзах эсхүл үнэлэхгүй байж болно.

19.10. Талууд нотлох баримтын талаар маргаагүй тохиолдолд тухайн баримтыг нотлох чадвартай гэж үзэж болно.

19.11. Талууд Арбитрын бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, нотлох баримтыг Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.

19.12. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр Талууд нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг шүүх болон бусад байгууллагад гаргаж, туслалцаа авч болно.

19.13. Арбитрын бүрэлдэхүүн нэг талын хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримт гаргах үүргийг нөгөө талд даалгаж болно.

19.14. Талууд Арбитрын бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, нотлох баримтыг Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй бол Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.

19.15. Талууд өөрөөр тохиролцоогүй бол, эсхүл Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол арбитрын ажиллагаанд Арбитрчдын зөвлөлөөс баталсан Нотлох баримтын журмыг баримтална.

20 дугаар зүйл. Арбитрын хуралдаан

20.1. Арбитрын хуралдаан нь танхим, цахим эсхүл хосолсон хэлбэртэй байж болно. Арбитрын хуралдааныг цахимаар явуулах тохиолдолд цахим хурлын удирдамжийг баримтлан явуулна.

20.2. Талууд арбитрын хуралдаанд биечлэн оролцохгүйгээр цугларсан нотлох баримтад үндэслэн маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлт гаргавал Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэж болно.

20.3. Арбитрын хуралдаан болох огноо, газар, цагийн талаар Талуудад урьдчилан мэдэгдэнэ.

20.4. Аль нэг тал арбитрын хуралдаанд Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд нөгөө талын хүсэлтийг харгалзан арбитрын хуралдааныг явуулах эсэх шийдвэр гаргана.

20.5. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол арбитрын хуралдааныг хаалттай явуулна.

20.6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга дуу бичлэгийн хэлбэрээр хөтөлнө. Хэргийн оролцогчид хуралдааны явцын дууны бичлэгтэй танилцаж болно.

20.7. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг аль нэг талын хүсэлтийг үндэслэн бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тал зардлыг арбитрын үндсэн болон нэмэлт зардал тооцох журамд заасны дагуу төлнө.

20.8. Арбитрын хуралдаанаас бусад ажиллагааны явцын тэмдэглэлийг дуу, зураг, дүрс бичлэг эсхүл бичгээр нарийн бичгийн дарга хөтөлж болно.

20.9. Нарийн бичгийн дарга хуралдааны товч тэмдэглэл хөтлөх бөгөөд уг тэмдэглэлд хуралдаан явуулсан газар, эхэлсэн, дууссан цаг, оролцогчдын нэр, хуралдааны дараалал, явц, гаргасан шийдвэрийн товч агуулгыг тусгана.

20.10. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын саналыг үндэслэн үндсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалал болон цагийн хуваарийг тогтооно.

20.11. Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэргийн оролцогчдын шаардлага, тайлбар, танилцуулгыг сонсож Талуудыг тайлбар хийх, мэтгэлцэх боломжоор хангасан гэж үзсэн тохиолдолд арбитрын хуралдааныг хаана.

20.12. Арбитрын үндсэн хуралдаан хаасны дараа Арбитрын бүрэлдэхүүн үндсэн шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргах хугацааг Талуудад мэдэгдэж болно.

21 дүгээр зүйл. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ

21.1. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтэд үндэслэн шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ /цаашид “түр арга хэмжээ” гэх/ авах эсхүл баталгаажуулах арга хэмжээний талаар урьдчилсан тогтоол гаргаж болно.

21.2. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар түр арга хэмжээг өөрчлөх, дуусгавар болгох эрхтэй.

21.3. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө аль нэг тал түр арга хэмжээ авхуулах хүсэлт гаргасан бол Арбитрын эрх бүхий этгээд тухайн хүсэлтийг шийдвэрлэх яаралтай арбитражийг 7 хоногийн дотор томилно.

21.4. Яаралтай арбитраж нь түр арга хэмжээ авхуулах хүсэлт, холбогдох баримтыг хянан үзэж, түр арга хэмжээ авах эсхүл татгалзах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана.

22 дугаар зүйл. Татгалзах эрхээ алдах

22.1. Аль нэг тал нь энэ Дүрэмд зааснаас өөрөөр тохиролцох боломжтой заалтын талаар, эсхүл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүй болохыг мэдэж байсан боловч тэр тухай даруй, эсхүл тогтоосон хугацааны дотор гомдол гаргахгүйгээр арбитрын ажиллагаанд үргэлжлүүлэн оролцсон бол түүнийг гомдол гаргах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

ДӨРӨВ. АРБИТРЫН ШИЙДВЭР

23 дугаар зүйл. Арбитрын шийдвэр, тогтоол гаргах

23.1. Хэргийг нэгээс илүү арбитраж шийдвэрлэж байгаа тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүнээс гарах аливаа шийдвэр, тогтоолыг олонхын саналаар гаргана.

23.2. Арбитрын бүрэлдэхүүн нь Арбитрын бүрэлдэхүүнийг татгалзах хүсэлт, арбитрын харьяаллыг шийдвэрлэх, түр арга хэмжээ авах тохиолдолд арбитрын шийдвэр /decision/, эвлэрлийг баталгаажуулах, маргааныг эцэслэн шийдвэрлэх тохиолдолд арбитрын үндсэн шийдвэр /award/ гаргана.

23.3. Арбитрын бүрэлдэхүүн Дүрмийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд буюу арбитрын ажиллагаатай холбогдуулан тогтоол /order/, шаардлагатай тохиолдолд урьдчилсан тогтоол /preliminary order/ гаргана.

23.4. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө эвлэрлийг баталгаажуулах хүсэлт хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Арбитрын эрх бүхий этгээдийн томилсон нэг арбитрч эвлэрлийг баталгаажуулна. Энэ тохиолдолд Дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсэгт заасан журмыг баримтална.

23.5. Арбитрын шийдвэр, үндсэн шийдвэр, тогтоол, урьдчилсан тогтоолыг бичгээр үйлдэх бөгөөд Талууд заавал дагаж мөрдөх, хугацаа алдалгүй биелүүлэх үүрэгтэй.

23.6. Талууд үндэслэл заах шаардлагагүй гэж санал нэгдсэнээс бусад тохиолдолд шийдвэрийн үндэслэлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгана.

23.7. Арбитрын үндсэн шийдвэрт Арбитрын бүрэлдэхүүн гарын үсэг зурах бөгөөд уг шийдвэр гарсан огноо болон Арбитрын ажиллагааны харьяаллыг дурдана. Аль нэг арбитрч гарын үсэг зураагүй эсхүл саналын зөрүүтэй бол энэ талаарх тайлбарыг арбитрын шийдвэрт тусгуулж болно.

23.8. Арбитрын үндсэн шийдвэрийг арбитрын хуралдааныг хаасан эсхүл Дүгнэлт-тайлбар ирүүлснээс хойш 14 хоногийн дотор бичгээр гаргана.

23.9. Арбитрын шийдвэр, тогтоолын эх хувийг хавтаст хэрэгт хадгалах болон Талуудад хүргэхэд хангалттай тоогоор үйлдэж Талуудад хүргэнэ.

23.10. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг Талууд бүрэн төлөх хүртэл арбитрын шийдвэр, тогтоолыг Талуудад хүргэх ажиллагааг хойшлуулж болно.

24 дүгээр зүйл. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, нэмэлт шийдвэр гаргах, тайлбарлах

24.1. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, шийдвэрийг тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах асуудлыг Арбитрын бүрэлдэхүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

24.2. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа Талуудад бичгээр мэдэгдэнэ.

25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

25.1. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг Талууд харилцан тохиролцох бөгөөд Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн тухайн маргааныг шийдвэрлэнэ.

25.2. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэх бөгөөд үүнд хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээ хамаарахгүй.

25.3. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг Талууд харилцан тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг шийдвэрлэхэд аль тохиромжтой гэж үзсэн материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

25.4. Талууд тусгайлан тохиролцож эрх олгосон бол Арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, эсхүл эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлэнэ.

25.5. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны заншил, ажил хэргийн практикийг харгалзан маргааныг шийдвэрлэж болно.

26 дугаар зүйл. Арбитрын зардал

26.1. Арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэнэ.

26.2. Арбитрын үндсэн зардлыг үндсэн болон сөрөг нэхэмжлэлийн үнийн дүнгээс тооцох бөгөөд арбитраг нэхэмжлэл гаргахдаа урьдчилан төлнө.

26.3. Арбитрын ажиллагааны явцад гарсан нэмэлт зардлыг тухайн ажиллагааны хүсэлт гаргасан тал Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд төлнө. Арбитрын ажиллагааг шуурхай явуулах зорилгоор арбитраг нэмэлт зардлыг холбогдох талаас арбитраг ажлын алба урьдчилан гаргуулж болно.

26.4. Арбитрын үндсэн болон нэмэлт зардлын хэмжээ, түүнийг тооцох аргыг “Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журам”-ын дагуу тогтооно.

27 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа дуусгавар болох

27.1. Арбитрын ажиллагаа нь арбитраг үндсэн шийдвэр /award/ эсхүл энэ Дүрмийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3-т заасан үндэслэлээр тогтоол гарснаар арбитраг ажиллагаа дуусгавар болно.

27.2. Арбитрын бүрэлдэхүүн арбитраг ажиллагааг дараах тохиолдолд дуусгавар болгоно:

27.2.1. арбитраг харьяаллын маргаан биш болох нь тогтоогдсон;

27.2.2. эрхийн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

27.2.3. нэхэмжлэлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн буюу арбитраг хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол;

27.2.4. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, нэхэмжлэлээ татан авсан, Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, биелүүлсэн;

27.2.5. Талууд эвлэрсэн;

27.2.6. Талууд арбитраг зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй;

27.2.7. бусад шалтгааны улмаас арбитраг ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагагүй эсхүл боломжгүй болсон.

27.3. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, Талууд арбитраг ажиллагааг дуусгавар болгох талаар хүсэлт гаргасан, эсхүл Хариуцагч

нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан бол Арбитрын эрх бүхий этгээд арбитрын ажиллагааг дуусгавар болгоно.

27.4. Талууд эвлэрсэн тохиолдолд эвлэрлийг арбитрын үндсэн шийдвэрээр баталгаажуулах хүсэлт гаргаж болно. Хэрэв арбитрын шийдвэрээр баталгаажуулах шаардлагагүй гэж үзвэл Арбитрт бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

28 дугаар зүйл. Түргэвчилсэн ажиллагаа

28.1. Нэхэмжлэлийн үнийн дүн 50,000,000 /тавин сая/ төгрөг болон түүнээс доош бол арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулна.

28.2. Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө нэхэмжлэлийн үнийн дүнгээс үл хамааран Талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар харилцан тохиролцож болно.

28.3. Түргэвчилсэн ажиллагаанд дараах журмыг баримтлах бөгөөд Дүрмийн бусад холбогдох заалтууд мөн үйлчилнэ:

28.3.1. арбитрын хэлэлцээрт гурван арбитрчаар маргааныг шийдвэрлүүлнэ гэж харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд маргааныг нэг арбитрч шийдвэрлэх бөгөөд тухайн арбитрчийг Арбитрын эрх бүхий этгээд томилно;

28.3.2. Талууд арбитрын хэрэг үүсгэсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор арбитрын ажиллагаа явуулах журмыг тогтооход энэхүү Дүрмийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасан асуудлаар өөрсдийн саналыг ирүүлэх үүрэгтэй;

28.3.3. арбитрч арбитрын ажиллагааг явуулах журмыг Талуудын урьдчилан бичгээр ирүүлсэн саналын үндсэн дээр тогтоох бөгөөд хэрэв Талууд санал зөрвөл арбитрч өөрөө тогтооно;

28.3.4. арбитрч арбитрын ажиллагаа явуулах журмыг бичгээр гарган, гарын үсэг зуран баталгаажуулж Талуудад хүргэнэ;

28.3.5. арбитрын хуралдааныг зайлшгүй тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн нэг удаа хойшлуулж болно;

28.3.6. арбитрч арбитрын ажиллагаанд Дүрмийн 28 дугаар зүйлийн 28.3.4 дэх заалтад заасан журмын дагуу явуулж хэргийг шийдвэрлэнэ;

28.3.7. Арбитраас хэргийн материалыг Арбитрын бүрэлдэхүүнд хүргэснээс хойш 60 хоногийн дотор арбитрын үндсэн шийдвэр гаргана. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн уг хугацааг нэг удаа сунгаж болно.

29 дүгээр зүйл. Нууцлал

29.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн, Арбитр, Талууд болон хэргийн оролцогч, арбитрын ажиллагааны талаар болон нотлох баримтын талаарх нууцыг хадгалах үүрэгтэй.

29.2. Арбитраас арбитрын шийдвэрийг Талууд болон Арбитрын бүрэлдэхүүний зөвшөөрөлтэйгөөр хэвлэн нийтэлж болно. Мөн арбитрын ажиллагаанд оролцсон этгээдүүдийн нэр болон бусдад танигдах байдлыг нууцлан арбитрын ажиллагааны талаар мэдээлэн, хэвлэн нийтэлж болно.

30 дугаар зүйл. Хариуцлага

30.1. Арбитр, Арбитрч нь арбитрын ажиллагаанд оролцсон үйлдэл, эс үйлдлийн төлөө хууль, дүрэмд зааснаас бусад хариуцлага хүлээхгүй.

ooOoo